

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.07.21

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ


- S&P 500 болон Nasdaq Composite индексүүд долоо хоногийн туршид бүх цагийн үеийн түүхэн дээд ханшуудаа хэд хэдэн удаа шинэчлэн тогтоолоо.
- Орлогын тайлангийн улирал мягмар гарагт албан ёсоор эхэлсэн бөгөөд хэд хэдэн томоохон банк орлогын тайлангаа зарлав.
- Долдугаар сарын эхээр анх удаа 4 их наяд ам.долларын зах зээлийн үнэлгээнд хүрсэн NVIDIA-ийн хувьцаа энэ мэдээгээр дахин өслөө.
- Инфляц өсч, жижиглэн худалдаа сэргэв. Хувьцааны хөрөнгө оруулагчид хэрэглээний болон инфляцын түвшин тогтвортой гэх эдийн засгийн мэдээллүүдийг эерэгээр хүлээн авлаа.
- Хятадын Үндэсний Статистикийн Газрын мягмар гарагт мэдээлснээр, тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) хоёрдугаар улиралд өмнөх оны мөн үеэс 5.2%-иар өссөн нь эхний улирлын 5.4%-ийн өсөлтөөс бага ч зах зээлийн хүлээлтээс өндөр байжээ.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

S&P 500 Index: Forward P/E ratio





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.07.14-07.20

ТАЙЛАН САЙН ГАРЧ ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ

S&P 500 болон Nasdaq Composite индексүүд долоо хоногийн туршид бүх цагийн үеийн түүхэн дээд ханшуудаа хэд хэдэн удаа шинэчлэн тогтоолоо. Үүнд АНУ-ын шилдэг компаниудын орлогын тайлангийн сайн үзүүлэлт болон эдийн засгийн нийтлэг эерэг мэдээлэл чухал нөлөөг үзүүллээ. Жижиг хувьцааг төлөөлдөг Russell 2000 индекс мөн өсөлттэй байсан бол Dow Jones Industrial Average болон S&P Midcap 400 индексүүд уналттай хаагдлаа.

Орлогын тайлангийн улирал мягмар гарагт албан ёсоор эхэлсэн бөгөөд хэд хэдэн томоохон банк орлогын тайлангаа зарлав. АНУ-ын хамгийн том банк болох JP Morgan Chase болон Citigroup хоёрдугаар улирлын орлогоо хүлээлтээс давуулан тайлагнажээ. Харин пүрэв гарагт PepsiCo, United Airlines, Netflix зэрэг хэрэглэгчдэд танил томоохон компаниудын орлогын тайлан мөн хүлээлтээс давж гарсан байна.

Бусад компанитай холбоотой мэдээнд, чип үйлдвэрлэгч NVIDIA компани H2O хиймэл оюуны чипээ Хятадад борлуулах зөвшөөрлийг Трампын засгаас авснаа зарлав. Долдугаар сарын эхээр анх удаа 4 их наяд ам.долларын зах зээлийн үнэлгээнд хүрсэн NVIDIA-ийн хувьцаа энэ мэдээгээр дахин өслөө.

Инфляц өсч, жижиглэн худалдаа сэргэв. Хувьцааны хөрөнгө оруулагчид хэрэглээний болон инфляцын түвшин тогтвортой гэх эдийн засгийн мэдээллүүдийг эерэгээр хүлээн авлаа. Тухайлбал, хэрэглээний үнийн индекс (CPI) сүүлийн таван сарын хамгийн өндөр өсөлтийг харуулсан ч таамаглалуудтай нийцсэн байна. CPI 6-р сард өмнөх сараас 0.3%-иар өссөн нь 5-р сарын 0.1%-иас нэмэгдсэн үзүүлэлт бөгөөд зарим эдийн засагчид үүнийг гаалийн нэмэлт тарифын өсөлттэй холбоотой гэж үзэж байна.

Жилийн дүнгээрээ инфляц 2.7%-д хүрсэн нь өмнөх сарын 2.4%-аас дээшилсэн үзүүлэлт юм. Хүнс болон эрчим хүчний хэлбэлзэлтэй үнийг хассан үндсэн CPI үзүүлэлт 2.9% болж өссөн нь 5-р сарын 2.8%-аас нэмэгдсэн байна. Гэр ахуйн бараа, амралт чөлөөт цагийн бараа, гутлын үнэ дөрөвдүгээр сараас хойш хурдацтай өссөн ч автомашины үнийн бууралт үүнийг бага зэрэг тэнцвэржүүлжээ.

Хөрөнгө оруулагчид мөн жижиглэн худалдааны тайланд анхаарал хандуулж, 6-р сард борлуулалт 0.6%-иар өссөн нь хүлээлтээс давж, 5-р сард 0.9%-иар буурсан байсан үзүүлэлтээ нөхсөн байна. Лхагва гарагт Ерөнхийлөгч Дональд Трамп Холбооны Нөөцийн дарга Жером Пауэллийг огцруулахаар төлөвлөж байна гэсэн мэдээ гарч, хувьцааны үнэ буурсан ч Трамп уг мэдээг няцааснаар уналт эргэн нөхөгджээ. Трамп нь энэ жил Холбооны Нөөц банк бодлогын хүүгээ бууруулахгүй байгаа талаар шүүмжилсээр ирсэн.

АНУ-ын Засгийн газрын дунд болон урт хугацаат үнэт цаасны өгөөж долоо хоногийн эцэст бараг өөрчлөгдсөнгүй, харин богино хугацаат өгөөж Жером Пауэллийн Холбооны Нөөцийн даргын албан тушаалын ирээдүйтэй холбоотой таамаг дунд үл ялиг буурав. АНУ-ын өндөр зэрэглэлийн (investment-grade) компанийн бондын зах зээл Засгийн газрын үнэт цааснаас илүү гүйцэтгэлтэй байлаа. Энэ ангиллын компанийн шинэ бондууд зах зээлийн хүлээлттэй нийцэж, ихэнх нь хэт захиалга (oversubscribed)-тай гарсан байна.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.07.14 – 07.20

ХЯТАДЫН ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ.

Хятадын эх газрын хувьцааны зах зээл долоо хоногийн турш өсөлттэй байв. FactSet-ийн мэдээлснээр, эх газрын голлох CSI 300 индекс 1.09%-иар, Shanghai Composite индекс 0.69%-иар өсжээ. Харин Хонконгийн Hang Seng индекс илүү хүчтэй өсөлт үзүүлж, 2.84%-иар дээшилсэн байна.

Хятадын Үндэсний Статистикийн Газрын мягмар гарагт мэдээлснээр, тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) хоёрдугаар улиралд өмнөх оны мөн үеэс 5.2%-иар өссөн нь эхний улирлын 5.4%-ийн өсөлтөөс бага ч зах зээлийн хүлээлтээс өндөр байжээ. Зарим шинжээч энэ өндөр гүйцэтгэл нь Бээжинг ойрын хугацаанд эдийн засгийг тэлэх шинэ арга хэмжээ авч хэрэгжүүлэх дарамтаас чөлөөлж болохыг онцолж байна.

Гэсэн хэдий ч шинжээчид оны хоёрдугаар хагаст эдийн засгийн өсөлт удаашрах эрсдэлтэйг анхааруулж байна. Үүнд дефляцын дарамт нэмэгдэх, жижиглэнгийн худалдааны өсөлт сулрах, мөн наймдугаар сарын дунд үеэр дуусах АНУ-тай хийсэн түр гэрээний дараа худалдааны маргаан дахин хурцадвал өсөлтөд сөргөөр нөлөөлнө гэж үзжээ. Энэ сарын эхээр Хятадын үйлдвэрлэгчдийн үнийн индекс (PPI) зургадугаар сард сүүлийн хоёр жилийн хамгийн хүчтэй уналтыг үзүүлж, 33 дахь сардаа дараалан үйлдвэрийн үнийн бууралт үргэлжилж байгааг харуулсан. Үйлдвэрийн үнийн индексийн бууралт болон Хятадын орон сууцны зах зээлд үүсэн сул байдал мөн засгийн газраас нэмэлт эдийн засгийн тэлэлтийн бодлого шаардах шалтгаан болж байна. Улсын хэмжээнд 70 хотын шинэ орон сууцны үнэ зургадугаар сард өмнөх сараас 0.27%-иар, хуучин орон сууцны үнэ 0.61%-иар буурсан тухай статистикийн газар мэдээлэв. Орон сууцны борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 12.6%-иар буурсан нь энэ оны хамгийн огцом уналт болжээ. Энэ нь тав дахь жилдээ үргэлжилж буй үл хөдлөхийн хямрал хэрэглээний эрэлтэд үргэлжлэн дарамт учруулж байгааг харуулж байна.



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
FASTENAL (FAST)	SimulationsPlus (SLP)	JPMORGAN CHASE & CO. (JPM)	J.B. HUNT (JBHT)	ASML (ASML)	UNITED (UAL)	tsmc (TSM)	NETFLIX (NFLX)	3M (MMM)
	FirstBank (FBK)	citi (C)	WALGREEN STORES (WAG)	BANK OF AMERICA (BAC)	KINDER MORGAN (KMI)	PEPSICO (PEP)	Interactive Brokers (IBKR)	Huntington (HMN)
	EQUITY BANCSHARES, INC. (EQBK)	BlackRock (BLK)	OmnicomGroup (OMC)	Goldman Sachs (GS)	Alcoa (AA)	GE Aerospace (GE)	MARTEN (MRTN)	REGIONS (RF)
		WELLS FARGO (WFC)	WaFd Bank (WAFD)	Johnson & Johnson (JNJ)	ISL GREEN REALTY CORP. (SLG)	CINTAS (CTAS)	BankOZK (OZK)	TRUIST (TFC)
		STATE STREET (STT)	FULFINANCIAL CORPORATION (FULF)	Morgan Stanley (MS)	SYNOVUS (SNV)	Abbott (ABT)	wipro (WIT)	slb (SLB)
		BNY (BK)	kestra (KMTS)	PROGRESSIVE (PGR)	Head & Shoulders (HOMB)	TCBI (TCBI)	Western Alliance Bancorporation (WAL)	AMERICAN EXPRESS (AXP)
		ERICSSON (ERIC)	Pinnacle FINANCIAL PARTNERS (PNFP)	PNC (PNC)	FIRST INDUSTRIAL REALTY TRUST (FRT)	USB (USB)	First National Bank (FNB)	charles SCHWAB (SCHW)
		angiodynamics (ANGO)		PROLOGIS (PLD)	AAR (AIR)	TRV (TRV)	Simmons Bank (SFC)	ally (ALLY)
		Albertsons Companies (ACI)		SANDVIK (MTB)	TriumphFinancial (TFN)	Webster Bank (WBS)	Metropolitan Commercial Bank (MCB)	Autoliv (ALV)
				M&T Bank (MTB)	Roxford Industrial (REXR)	FIFTH THIRD BANK (FTB)	COHEN & STEERS (CNS)	Cumena (CMA)

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
verizon (VZ)	NXP (NXPI)	Coca-Cola (KO)	SAP (SAP)	GE VERNOVA (GEV)	Alphabet (GOOGL)	American Airlines (AAL)	intel (INTC)	CENTENE (CNC)
Steel Dynamics, Inc. (STLD)	AGNC (AGNC)	LOCKHEED MARTIN (LMT)	INTUITIVE SURGICAL (ISRG)	TESLA (TSLA)	servicenow (NOW)	The Blackstone Group (BX)	Newmont (NEM)	HCA Healthcare (HCA)
CLIFFS (CLF)	AGNC (AGNC)	PHILIP MORRIS INTERNATIONAL (PM)	ENPHASE (ENPH)	AT&T (T)	IBM (IBM)	DOW (DOW)	DECKERS BRANDS (DECK)	AutoNation (AN)
DYNEX CAPITAL INC. (DX)	Calix (CALX)	gm (GM)	TEXAS INSTRUMENTS (TXN)	Amphenol (APH)	CHIPOTLE (CMG)	Southwest (LUV)	PROSICAN BEAUTY TRUST (DOC)	Booz Allen Hamilton (BAH)
Roper TECHNOLOGIES (ROP)	CROWN (CRO)	DR-HORTON (DHI)	Capital One (COF)	ThermoFisher SCIENTIFIC (TMO)	QuantumScope (QSI)	NOKIA (NOK)	BYD (BYD)	Charter COMMUNICATIONS (CHTR)
RYANAIR (RYA)	agilysys (AGYS)	RTX (RTX)	RANGE RESOURCES (RRC)	fiserv. (FIS)	Creality AUTO PARTS (CRLY)	UNION PACIFIC (UNP)	Edwards SCHL (EWS)	GRAFTECH International (EAF)
HBT Financial (HBT)	RLI (RLI)	KeyBank (KEY)	Matador (MTDR)	GENERAL DYNAMICS (GD)	Alaska AIRLINES (ALK)	Honeywell (HON)	WYERHAEUSER (WY)	GENTEX CORPORATION (GNTX)
PREFERRED BANK (PPBC)	BOK FINANCIAL (BOKF)	DANAHER (DHR)	EQT (EQT)	NEXTERA ENERGY (NEE)	flex (FLEX)	Keurig DrPepper (KDP)	sallie mae (SLM)	TriNet (TNET)
MEDPACE (MEDP)	NORTHROP GRUMMAN (NOC)	CHUBB (CB)	CoStar Group (CSGP)	Lamb Weston (LW)	United Rentals (URI)	ORCHID ISLAND (ORC)	OneMain Financial (OMF)	WABASH (WNC)
Berkley (WRB)	MSCI (MSCI)			Mr. Cooper Group (COOP)				

http://eps.sh/cal © 2025 Earnings Whispers